

Дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах
төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд Япон Улсын “Жайка” олон улсын байгууллагын мэргэжилтний багтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт тохиолдож болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг гамшгаас хамгаалах болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх, газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах байнгын ажиллагаатай Ажлын хэсгийг байгуулсугай.

2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, үүрэг чиглэлээр хангаж ажиллахыг Ажлын хэсэг /А.Дамцагдорж, С.Эрдэнэбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч /Ж.Лхагвасүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ